



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 14/62

Мандалговь

“Аймгийн музейд шаардлагатай дохиолол
хамгаалалын тоног төхөөрөмж” нийлүүлэгчийг
сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн музейд шаардлагатай дохиолол хамгаалалын тоног төхөөрөмж” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Одончимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Ц.Эрдэнээ (Иргэний төлөөлөл)
Б.Батхүү (Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)
Д.Мөнхцоож (Хот тохижуулах газрын ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын ХАА хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Одончимэг)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482062367